МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 18

НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭНД ГЭНЭТИЙН ШАЛГАЛТ ХИЙЖЭЭ



Баянзүрх дүүргийн прокурорын газраас санаачлан түүхий нүүрсийг зохих зөвшөөрөлгүй түлж агаар бохирдуулж буй зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор тус дүүрэг дэх Цагдаагийн гуравдугаар хэлтэстэй хамтран "Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, зөвшөөрлийн бичиг олгох гурвалсан гэрээтэй уурын зуухны үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох" чиглэлээр нэгдсэн удирдамж бүхий ажил зохион байгуулсан байна.

Тус удирдамжид заасан хуваарийн дагуу Баянзүрх дүүргийн прокурорын газрын прокуроруд болон дүүрэг дэх Цагдаагийн гуравдугаар хэлтсийн хэсгийн байцаагчдын хамтарсан 4 ажлын хэсэг энэ оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 18-аас 22 цагийн хооронд дүүргийнхээ 8-12, 7, 20, 28 дугаар хороодын нутаг дэвсгэрт түүхий нүүрсээр галладаг 27 уурын зуухны үйл ажиллагааг гэнэтийн байдлаар шалгажээ.



Мөн шалгалтаар дээрх хороодод түүхий нүүрс түлж буй айл байгаа эсэх, гэрээний дагуу уурын зуухнуудын яндангийн хэсэгт утаа шүүгч суурилуулсан эсэх, нүүрс алдагдах, зарж борлуулахаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэхийг газар дээр нь үзэж, танилцсан байна.

Агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн тус шалгалтаар ил задгай нүүрсээ байлгадаг, харуул хамгаалалт муу, тоног төхөөрөмжид шүүлтүүр суулгасан эсэх нь тодорхойгүй зэрэг хэд хэдэн зөрчил илэрчээ. Иймд шалгалтын ажлын хэсгээс зөрчил илэрсэн газруудад тодорхой заавар, зөвлөмжийг өгч, зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх талаар хугацаатай үүрэг өгч ажилласан байна.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2921